

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: [khuanganm@audit.gov.mn](mailto:khuanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: [uuriintuya.b@audit.gov.mn](mailto:uuriintuya.b@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

**АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  4. Аудитын тайлан.....
    - 4.1 Ерөнхий зүйл.....
    - 4.2 Материаллаг байдал .....
    - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
    - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
    - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
    - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
  5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....
- 

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ХДТ	Хөгжимт драмын театр

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН  
ДАРГА Ж.САЙГУЛИК ТАНАА

2023.02.20 № 105  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Хөгжимт дармын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Хөгжимт дармын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 33098 хүнд соёлын үзвэр, үйлчилгээ үзүүлж 41.4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

#### Аудитын гол асуудал

Халаалтын хуримтлагдсан өр төлбөр 138.1 сая төгрөгт хүрсэн асуудалд анхаарах шаардлагатай байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>86,076,347.00</u></b>	<b><u>118,526,770.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	1,050,176.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	1,050,176.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	1,050,176.00
31211	Төрийн сангийн харилцах	-	1,010,176.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	40,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	40,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	40,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	40,000.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
34600	Урьдчилж гарсан зардал	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	86,036,347.00	117,476,594.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	86,036,347.00	117,476,594.00
35410	Бичиг хэргийн материал	130,500.00	130,500.00
35420	Аж ахуйн материал	30,178,657.00	49,059,444.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,095,124,753.28</u></b>	<b><u>5,912,944,038.45</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,095,124,753.28	5,912,944,038.45
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,943,219,753.28	5,759,539,038.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,328,073,700.96	6,343,073,700.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(561,490,730.28)	(748,654,307.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,500,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,041,666.53)	(31,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,859,378.00	193,748,078.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(94,772,547.38)	(129,640,228.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,002,349.00	175,307,349.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(162,373,259.00)	(164,431,869.12)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	151,905,000.00	153,405,000.00
39301	Програм хангамж	575,000.00	2,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(575,000.00)	(575,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,181,201,100.28</u></b>	<b><u>6,031,470,808.45</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>92,196,490.00</u></b>	<b><u>138,739,444.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	92,196,490.00	138,739,444.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	92,196,490.00	138,739,444.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	92,196,490.00	138,739,444.00

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	92,196,490.00	138,739,444.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,089,004,610.28</u></b>	<b><u>5,892,731,364.45</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,089,004,610.28	5,892,731,364.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,055,006,814.00	1,055,006,814.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(1,204,283,501.60)	(1,400,556,747.43)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,204,283,501.60)	(1,204,283,501.60)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(196,273,245.83)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,181,201,100.28</u></b>	<b><u>6,031,470,808.45</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,146,542,900.00</b>	<b>1,369,324,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>46,391,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	46,391,800.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	46,391,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,575,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,820,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	4,996,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,146,542,900.00</b>	<b>1,322,933,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	883,976,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	883,976,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,702,000.00</b>	<b>15,087,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,587,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,702,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,108,840,900.00</b>	<b>423,869,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,108,840,900.00	408,869,300.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	15,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,443,404,964.45</b>	<b>1,565,598,045.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,443,404,964.45</b>	<b>1,565,598,045.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,438,748,811.45	1,563,802,978.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	667,440,176.00	743,730,070.00

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	536,376,815.00	539,658,691.00
210102	Нэмэгдэл	99,850,211.00	123,524,679.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,213,150.00	39,336,200.00
210104	Урамшуулал	-	41,210,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,864,830.00</b>	<b>93,157,939.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,318,138.00	63,347,739.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,718,099.00	7,452,275.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,361,037.00	5,961,830.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,315,233.00	1,490,436.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,152,323.00	14,905,659.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>405,560,455.00</b>	<b>426,908,230.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,414,888.00	8,098,974.00
210302	Түлш, халаалт	394,098,467.00	412,329,754.00
210303	Цэвэр, бохир ус	6,047,100.00	6,479,502.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,968,140.00</b>	<b>3,693,412.00</b>
210401	Бичиг хэрэг	368,400.00	1,113,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,200.00	1,547,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,540.00	386,162.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	209,000.00	646,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>550,900.00</b>	<b>811,700.00</b>
210502	Хоол, хүнс	-	306,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,900.00	504,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,277,645.00</b>	<b>10,634,840.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	34,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,080,000.00
210604	Урсгал засвар	11,277,645.00	9,520,240.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>1,332,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	1,332,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,651,468.00</b>	<b>23,438,723.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,299,040.00	23,438,723.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	182,850.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	31,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	-
210807	Газрын төлбөр	517,578.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>252,435,197.45</b>	<b>260,096,064.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,601,000.00	26,926,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	237,834,197.45	233,169,414.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,656,153.00</b>	<b>1,795,067.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	700,000.00

2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,656,153.00	1,095,067.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,656,153.00	1,095,067.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(296,862,064.45)</u></b>	<b><u>(196,273,245.83)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(296,862,064.45)</u></b>	<b><u>(196,273,245.83)</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,146,542,900.00</u></b>	<b><u>1,349,328,800.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>41,395,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	41,395,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	41,395,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,575,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,820,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,146,542,900.00</b>	<b>1,307,933,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	883,976,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		883,976,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,702,000.00</b>	<b>15,087,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14,587,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,702,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,108,840,900.00</b>	<b>408,869,300.00</b>

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,108,840,900.00	408,869,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,146,542,900.00</u></b>	<b><u>1,317,285,924.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,146,542,900.00</u></b>	<b><u>1,317,285,924.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>1,141,886,747.00</u></b>	<b><u>1,315,490,857.00</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	667,971,961.00	743,730,070.00
210101	Үндсэн цалин	536,908,600.00	539,658,691.00
210102	Нэмэгдэл	99,850,211.00	123,524,679.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,213,150.00	39,336,200.00
210104	Урамшуулал	-	41,210,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,864,830.00	93,157,939.00
210201	Тэтгэврийн даатгал	60,318,138.00	63,347,739.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,718,099.00	7,452,275.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,361,037.00	5,961,830.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,315,233.00	1,490,436.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,152,323.00	14,905,659.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	348,626,688.00	380,365,276.00
210301	Гэрэл, цахилгаан	4,982,588.00	8,098,974.00
210302	Түлш, халаалт	337,164,700.00	365,786,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,479,400.00	6,479,502.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b><u>2,028,140.00</u></b>	<b><u>3,647,412.00</u></b>
210401	Бичиг хэрэг	368,400.00	1,139,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,200.00	1,534,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,540.00	372,962.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	269,000.00	600,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b><u>550,900.00</u></b>	<b><u>857,700.00</u></b>
210502	Хоол, хүнс		306,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,900.00	550,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,113,000.00	26,722,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		34,600.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	10,081,000.00	24,187,740.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	1,332,000.00
210702	Дотоод албан томилолт		1,332,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,130,228.00	31,528,470.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,777,800.00	31,528,470.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	182,850.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	31,500.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	

210807	Газрын төлбөр	517,578.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,601,000.00</b>	<b>34,149,650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,601,000.00	34,149,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,656,153.00</b>	<b>1,795,067.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		700,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,656,153.00	1,095,067.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,656,153.00	1,095,067.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	≡	<b><u>32,042,876.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>30,992,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>30,992,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	30,992,700.00
220001	Барилга байгууламж		
222001	Тоног төхөөрөмж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	30,992,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	≡	<b><u>(30,992,700.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
14	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	1,050,176.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		1,050,176.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	(1,204,283,501.60)	6,089,004,610.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	(1,204,283,501.60)	6,089,004,610.28
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайланг үеийн үр дүн				
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	(1,204,283,501.60)	6,089,004,610.28
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	(1,204,283,501.60)	6,089,004,610.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	(1,204,283,501.60)	6,089,004,610.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайланг үеийн үр дүн			(196,273,245.83)	(196,273,245.83)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	(1,400,556,747.43)	5,892,731,364.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,292,846,000.00</b>	<b>1,290,740,757.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,292,846,000.00</b>	<b>1,290,740,757.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,292,078,000.00</b>	<b>1,290,040,757.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>744,730,600.00</b>	<b>743,730,070.00</b>
210101	Үндсэн цалин	540,659,200.00	539,658,691.00
210102	Нэмэгдэл	123,524,700.00	123,524,679.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,336,200.00	39,336,200.00
210104	Урамшуулал	41,210,500.00	41,210,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>93,270,500.00</b>	<b>93,157,939.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,423,800.00	63,347,739.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,461,600.00	7,452,275.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,969,300.00	5,961,830.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,492,400.00	1,490,436.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,923,400.00	14,905,659.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>380,365,400.00</b>	<b>380,365,276.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,099,000.00	8,098,974.00
210302	Түлш, халаалт	365,786,800.00	365,786,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,479,600.00	6,479,502.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,194,300.00</b>	<b>2,095,962.00</b>
210401	Бичиг хэрэг	368,400.00	337,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,200.00	1,116,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	416,700.00	372,962.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	269,000.00	269,000.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	550,900.00	550,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,900.00	550,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,500,000.00	6,405,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,905,240.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	820,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	820,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	43,466,300.00	43,245,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,466,300.00	43,245,170.00
210803	Даатгалын үйлчилгээ		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,000,000.00	19,670,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	19,670,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	768,000.00	700,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	768,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	700,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,292,846,000.00</b>	<b>1,291,750,933.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>883,976,700.00</b>	<b>883,976,700.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	883,976,700.00	883,976,700.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>408,869,300.00</b>	<b>407,774,233.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	408,869,300.00	407,774,233.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		1,010,176.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>67</b>	<b>67</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	53	53
620003	Үйлчлэх ажилтан	13	13
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>67</b>	<b>67</b>
650006	Соёл урлагийн салбарын терийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	54	54
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>37,702,000.00</b>	<b>56,442,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>37,702,000.00</b>	<b>56,442,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	37,702,000.00	56,442,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,500,000.00	-
210302	Түлш, халаалт	14,500,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,551,450.00
210402	Тээвэр, шатахуун		417,800.00
210404	Ном, хэвлэл		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		331,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	306,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		306,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,081,000.00	32,497,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,134,600.00
210602	Тавилга		5,680,000.00
210604	Урсгал засвар	10,081,000.00	21,682,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	512,000.00
210702	Дотоод албан томилолт		512,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,520,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,520,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,601,000.00	21,575,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,601,000.00	21,575,450.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>37,702,000.00</b>	<b>56,482,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,702,000.00</b>	<b>56,482,800.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14,587,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,702,000.00	41,395,800.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		40,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театр нь соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах, соёлын ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Соёлын яамны харьяа байгууллага юм.

Тус театр нь 2022 онд үндэсний уламжлалт болон орчин үеийн соёл урлагийг хөгжүүлэх, хүн төрөлхтний бүтээн бий болгосон соёлын биет ба биет бус өв, ёс заншлыг ард иргэдэд хүргэх, ажилчдын ажлын амжилтыг ахиулахад чиглэж ажилласан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- Соёлын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нийгмийн даатгал, Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ. Тус байгууллагад дотоод аудитын нэгж ажилладаггүй.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

**Хөгжимт драмын театр** нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Хөгжимт драмын театр нь байгууллагын даргын 2020 оны А/17 тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 149.7 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1,050.2	1,050.18
Авлага	40.0		(40.00)
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал	86,036.3	117,476.6	31,440.25
Үндсэн хөрөнгө	6,095,124.8	5,912,944.0	(182,180.71)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,181,201.1</b>	<b>6,031,470.8</b>	<b>(149,730.3)</b>
Өр төлбөр	92,196.5	138,739.4	46,543.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,089,004.6	5,892,731.4	(196,273.2)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,181,201.1</b>	<b>6,031,470.8</b>	<b>(149,730.3)</b>

Хүснэгтээс харахад өмнөх оноос үндсэн хөрөнгө 182.2 сая, Засгийн газрын хувь оролцоо данс 196.3 сая төгрөгөөр буурч, мөнгөн хөрөнгө 1.0 сая, бараа материалын данс 31.4 сая, өр төлбөр данс 46.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Оны эхэнд бараа материалын данс 86.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр нийт 67.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 36.3 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 117.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 7,043.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 31.0 сая төгрөгийн хөрөнгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 15.0 сая төгрөгийн барилгын сайжруулалтын урсгал засвар, Өлгий сумын ОНХС-ийн хөрөнгөөр 5.0 сая төгрөгийн хөгжмийн зэмсэг зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,293.7 сая, нийт зарлагыг 1,293.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 0.9 сая төгрөгөөр бууруулж, 1292.8 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотой түлш халаалт, гэрэл цахилгаан, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, БГАҮТөлбөр хураамжийн зардлуудыг бууруулж баталсантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 884.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 408.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж нийтдээ 1292.8 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 884.0 сая төгрөгийн, орон нутгаас 407.8 2.5 сая төгрөгийн бүрдүүлж нийтдээ 1291.8 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст орон нутгийн төсөвт 1.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1290.7 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	843,208.70	842,266.60	(942.10)	99.9
2	80112-Нийтлэг үйлчилгээ	408,869.30	407,774.20	(1,095.10)	
3	80214-Уран бүтээл хийлгэх	40,000.00	40,000.00	-	100.0
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	768.00	700.00	(68.00)	91.1
	<b>Дүн</b>	<b>1,292,846.00</b>	<b>1,290,740.80</b>	<b>(2,105.20)</b>	<b>99.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөгжимт драмын театр нь аймгийн ЗДНХ-өөс 14.6 сая төгрөгийн, аймгийн Соёлын урлагийн газраас 0.5 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 30.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 10.8 сая төгрөгийн нийтдээ 56.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж зарцуулсан байна.

Зарцуулалтыг үзэхэд: хангамж, бараа материалын зардалд 1.6 сая, нормативт зардалд 0.3 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 32.5 сая, томилолт зочны зардалд 0.5 сая, Бараа үйлчилгээний бусад зардалд 21.6 сая төгрөгийн тус тус зарцуулалтын эрх авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Аймгийн Хөгжимт драмын театр нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

**Хөгжимт драмын театрын** 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аймгийн аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1443.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 28.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалингийн зардлаас 1.0 сая, НДШ-ийн зардлаас 0.1 сая, хангамж, бараа материалын зардлаас 0.1 сая, урсгал зардлаас 0.1 сая, томилолтын зардлаас 0.2 сая, бусдаар болон бараа үйлчилгээний зардлаас 0.5 сая, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 0.07 сая төгрөгийг тус тус хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил гараагүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Хөгжимт драмын театр нь 2022 онд нийт 1715.8 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүрэн мэдээлсэн хэрэгжилтийн хувь 100% байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөгжимт драмын театрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Театрын өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1.4 сая төгрөгийн акт, 2.4 сая төгрөгийн зөрчил арилгах зөвлөмж өгөгдсөнийг арилгаж, биелэлтийг ирүүлж ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25.9 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөв.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах 29.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 29,492.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төрийн цахим худалдан авалтын системийн цахим дэлгүүрт бүртгэгдээгүй 5 аж ахуйн нэгжээс худалдан авч “цахим дэлгүүрт байршсан бараа, ажил үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн төрийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлээгүй байна.

#### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тайлант онд төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийг төрийн цахим худалдан авалтын системийн цахим дэлгүүрт бүртгэгдээгүй 5 аж ахуйн нэгжээс худалдан авч төрийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлээгүй байна.	1	29,492.7			1	29,492.7							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>29,492.7</b>				<b>29,492.7</b>							

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

---